



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Байнгын ажиллагаатай суурин станцын
солбицол, хурдны вектор утга батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны А/112 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулагдсан байнгын ажиллагаатай суурин станц /GNSS/-уудын солбицол, хурдны вектор утгыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан солбицол, хурдны вектор утгыг GNSS-ийн онлайн боловсруулалтын "Monpos" системд бүртгэсүгэй.

3. Улсын хэмжээнд GNSS-ийн зураглалын болон түүнээс дээд ангийн сүлжээний тэгшитгэн бодолтыг "Monpos" системээр гүйцэтгэхийг Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

4. GNSS-ийн байнгын ажиллагаатай бусад станцын солбицол, хурдны вектор утгыг олон улсын GNSS-ийн сүлжээнд тодорхойлж 2023 оны I улиралд багтаан батлуулах ажлыг Геодези, зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/-т даалгасугай.

5. Улсын хэмжээнд ажиллаж буй станцуудын хэвийн ажиллагааг хангаж, техник болон програм хангамжийг шинэчлэх ажлыг зохион байгуулахыг Геодези зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс /Д.Нямдаваа/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т тус тус даалгасугай.

ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ



1502010027

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын даргын 2022 оны
дугаар тушаалын хавсралт



GNSS-ИЙН БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ СТАНЦЫН СОЛБИЦОЛ,

ХУРДНЫ ВЕКТОР УТГА

БАСС нэр	Байнгын ажиллагаатай станцын солбицол (Картезиан)			Хурдны вектор утга			Эрин
	X (m)	Y (m)	Z (m)	Vx (m/y)	Vy (m/y)	Vz (m/y)	
BOA1	3288.122	4197450.467	4788430.377	-0.02810	0.00120	0.00250	2005.00
GSA1	-1391414.487	4185665.102	4593318.169	-0.02998	-0.00190	-0.00573	2005.00
SEA1	-1140135.157	3925546.529	4880360.865	-0.02888	-0.00089	-0.00451	2005.00
SUA1	-1733071.506	4026927.958	4618414.641	-0.02278	-0.02034	-0.00654	2005.00
ZAV1	-512176.221	4267410.327	4699017.350	-0.03026	0.00125	-0.00109	2005.00
OVA1	-977156.360	4308800.747	4587095.574	-0.02997	-0.00020	-0.00395	2005.00